



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/16

Чингис хот

Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3.2, 30.3.4, Засгийн газрын 2020 оны 147 дугаар тогтоол, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны тогтоолоор баталсан Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрмийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрийн бодлого хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангах үүрэг бүхий Хөдөлмөрийн эрхлэлтийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Дарга

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн
дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
Хөдөлмөрийн хэлтсийн дарга

Гишүүд

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Ажил олгогч эздийн холбооны тэргүүн

Ажил олгогч эздийн холбооны тэргүүлэгч-2

Үйлдвэрчний хорооны дарга

Үйлдвэрчний хорооны гишүүн-2

2. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдууг ан аймгийн Засаг даргын 2016 оны А/501 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010068